

ОРОН НУТГИЙН ИХ, ДЭЭД СУРГУУЛИУДЫН ЭЛСЭЛТИЙН БАЙДАЛ, БОДЛОГЫН ЗОРИЛТ, ХЭРЭГЖИЛТ

Баяржаргалын Цог, магистр
b.tsog@dornod.edu.com
Дорнод их сургууль

Хураангуй

Сүүлийн 5 жилийн хугацаанд орон нутгийн их, дээд сургуульд суралцагчдын тоо жил ирэх тусам буурч байгаа нь сургуулиудын санхүүжилтэд нөлөөлдөг.

Их дээд сургуулиудын элсэлтийн бодит нөхцөл байдлыг судалж тодруулах, цаашид авах арга хэмжээг тодорхойлох шаардлагатай юм. Энэхүү асуудлыг зохицуулахад төр, засгийн бодлогын хэрэгжилт, зарим зохицуулалт чухал нөлөөтэй бөгөөд судалгааны асуудалтай холбоотой төрийн бодлого, зорилтын хэрэгжилтийн байдал хангалтгүй байна. Зах зээлийн хуулиар оюутны тоо, элсэгчийн тоо их, бага байх нь тухайн сургуулийн хүлээн зөвшөөрөгдсөн байдалтай холбоотой ч, төсвийн голлох эх үүсвэр болох оюутны сургалтын төлбөрөөс орж ирэх санхүүжилт буурсан, төрөөс олгодог байсан тогтмол зардлын санхүүжилт зогссон зэрэг өнөөгийн нөхцөл нь орон нутгийн их, дээд сургуулиудад хүндрэл үүсч, зарим бодлого, зохицуулалтыг шинэчлэх болсон гэдгийг маш тодорхой харуулж байна.

Нэгэнт төрөөс санхүүжүүлэх боломжгүй болсон ийм нөхцөлд хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэнд баримжаалан элсэлттэй холбоотой зохицуулалт шаардагдаж байна. Энэ хүрээнд хамгийн түрүүнд төв, орон нутгийн их, дээд сургуульд бэлтгэгдэж байгаа мэргэжлийн хөтөлбөрийн давхардлыг арилгах хэрэгтэй. Тиймээс орон нутагт үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургуулийн элсэлтийн өнөөгийн байдлыг судалж, шийдвэрлэх боломж, арга замыг хайх шаардлага үүсч байна.

Түлхүүр үг: Боловсролын хэрэгцээ, элсэлт, хөтөлбөрийн давхардалт, дэмжлэг

Оршил

1990 оноос хойш ардчилал, зах зээлийн өөрчлөлт шинэчлэлийн үр дүнд дээд боловсролын салбарт томоохон өөрчлөлтүүд хийгдсэн. Хөдөлмөрийн зах зээл дээр өндөр ур чадварын эрэлт хэрэгцээ нэмэгдсэн нь дээд боловсролд хувийн секторын оролцоог хуульчилснаар дээд боловсрол эзэмших явц өргөжин тэлсэн байна. (боловсрол, 2010.03) 2003-2004 оны хичээлийн жилд дээд боловсролын сургалтын байгууллагын тоо 183, оюутны тоо 108738 болж огцом өссөн үед иргэдийн боловсрол эзэмших хэрэгцээг хангах, сургуулиудын оршин тогтнох нөхцөл болох санхүүгийн байдалд сайн нөлөөтэй байсан. Сүүлийн жилүүдэд улсын хэмжээнд их, дээд сургуулийн элсэлт багассан өнөөгийн байдлыг судалж, шийдвэрлэх боломж, арга замыг хайх

шаардлага үүсч байна.

Зорилго: Орон нутгийн их, дээд сургуулийн элсэлтийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох

Зорилт: 1. Монгол улсын орон нутгийн их дээд сургуулиудын статистик, төр засгийн бодлогын баримт бичгүүдэд шинжилгээ хийх


Орон нутгийн их сургуулиудын багш нараас элсэлтийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох

Судалгааны арга: Баримт бичгийн шинжилгээний арга, Асуулгын аргуудыг ашигласан

Судалгааны үндсэн хэсэг:

1.Төв, орон нутгийн их, дээд сургуулийн элсэлтийн харьцаа

Сүүлийн 17 жилд дээд боловсролын сургуулийн суралцагчдын тоо хэрхэн өөрчлөгдсөнийг 3 үечлэлээр, төв, орон нутгаар ялган авч үзвэл:



Зураг 1. /Эмхэтгэл/

2018-2019 оны хичээлийн жилд орон нутагт салбар сургууль 17 байна. ЗГ-аас 2012 онд төрийн өмчийн 42 сургуулийг нэгтгэж 16 болгосон, хувийн хэвшлийн сургуулийн тоо 79 болж буурсан ба баруун бүсэд Ховд их сургууль, зүүн бүсэд Дорнод их сургуулиудыг бүсийн төв их сургууль байхаар тогтоосон.

Монголын их дээд сургуулиудын төсөвийн голлох байр суурийг оюутны сургалтын төлбөр эзэлсэн хэвээр байна.



Зураг 2. /БСШУ Боловсролын чанарын шинэчлэлийн бодлого 2012-2016/

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургуулиудад сүүлийн 10 орчим жилд элсэлтийн тоо буурснаар санхүүгийн байдал хүндрэх болсон.

Засгийн газар, бодлогын яамнаас элсэлттэй холбоотой нэгдсэн бодлого барьж ажиллах нь бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бодлогыг хэрэгжүүлэх, их сургуулиудыг хотхоноор хөгжүүлэх чиглэлийн хэрэгжүүлэхэд чухал нөлөөтэй гэж үзэж байна.

Монгол улсад сүүлийн 5 жилд дээд боловсролд хамрагдалтын статистикийн тайлангаас үзвэл:

	Суралцагчид (бүс нутгаар)					
	Бүгд	УБ хотод	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс
2014-2015	178,295	161,632	4,982	4,607	6,273	801
2015-2016	162,626	148,077	4,717	4,066	5,058	708
2016-2017	157,138	143,684	4,211	4,284	4,308	651
2017-2018	155,248	144,061	3,666	3,099	3,740	681
2018-2019	157,625	146,024	3,870	3,016	3,997	718

Хүснэгт 1. Суралцагчдын тоо (байршлаар)

2014-2015 оны хичээлийн жилд нийт суралцагчид орон нутагт 9,3 % байсан бол 2018-2019 оны хичээлийн жилийн статистикт мэдээгээр 7.3 % болж багассан нь хөдөө орон нутгийн сургуулиудад (салбар сургуулиуд ороод) суралцагчид (БСШУСЯ, 2019) сүүлийн 5 жилийн хугацаанд улсын хэмжээгээр буурсан.

Орон нутгийн их, дээд сургуулийн багш нараас авсан судалгаанд оюутны тоо огцом буурсан гэж үзэж байна.



Зураг 3.

Элсэгчдийн тоо ингэж огцом буурах нь сургуулиудын санхүүгийн байдал, сургалт, эрдэм шинжилгээний ажлын чанар, хүртээмжид ч нөлөөлж байна. Их, дээд сургуулиуд орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг тогтмол

эрэлхийлж эрдэм шинжилгээ, судалгааны төсөл, захиалгат ажлуудыг гүйцэтгэх, орлогоо нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаж байгаа ч нөхцөл байдал ямар байгааг судлах хэрэгтэй.

2. Элсэлттэй холбоотой бодлого, зорилт, хэрэгжилт:

Дээд боловсролыг хөгжүүлэх асуудлаар төр засгийн авч хэрэгжүүлэх бодлогыг дараах үндсэн хоёр чиглэлээр тодорхойлж болох талтай.

1. Хууль, эрх зүйн зохицуулалт болон бодлого хөтөлбөрүүд хэрэгжүүлэх зохицуулалтын дэмжлэг
2. Бодит санхүүжилт буюу төрөөс шууд санхүүжүүлэх дэмжлэг

Дээд боловсролын талаар улс орон ямар бодлого баримталж байгаагаас шалтгаалж дээд боловсролын санхүүжилтийн төрлүүдийг Stiglitz (2000) бичжээ. Үүнд: Дээд боловсролын өртгийн ихээхэн хэсгийг улсаас санхүүжүүлэх, Тэтгэлэг тусламж олгох –Зарим улс тэтгэлэг тусламж олгох хүүхдийн тоог сургуультай тохиролцож, хүүхдийн тоогоор тооцож сургуулийг санхүүжүүлдэг. Тэтгэлэг тусламжийг оюутанд өөрт нь өгдөг байна. Сургалтын төлбөрийн татварын хөнгөлөлт, зээл олгох хөдөлмөр эрхэлсний дараа татварын байгууллагатай хамтран нөхөн төлүүлэх хөтөлбөртэй улс орон-Австрали улсад их, дээд сургуулийн оюутны зээлийн хөтөлбөрт (HECS) хамрагддаг. (Заяадэлгэр.А, 2011) Дээд боловсролын санхүүжилтийн асуудлыг зохицуулах чиглэлээр Монгол улсын ИХ, ЗГ, БСШУ-ны сайдын тушаалаар батлагдсан баримт бичиг цөөнгүй байдаг.

Судалгааны үр дүн: Нэгдүгээрт: Бодлогын баримт бичигт:

1. Элсэлтийг мэргэжлийн хэрэгцээтэй уялдуулах, (зураглал, 2018)
2. Төрийн өмчийн сургуулиудын мэргэжилтэн бэлтгэж буй сургалтын хөтөлбөрийн давхардлыг арилгаж зохистой болгох, (зураглал, 2018)
3. Дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын хөтөлбөрийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэх, (бодлого, 2018)
4. Монгол улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 4.7.1.а. бүсчилсэн хөгжлийг төрөөс дэмжих эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх; 4.7.4. нийгэм, соёлын хүрээнд: 4.7.4.а. бүсүүдэд их сургууль, коллежийн салбар, судалгаа, мэдээллийн болон сургалтын төвүүд байгуулахыг дэмжиж тухайн бүс нутгийн хөгжлийн чиглэлтэй уялдсан боловсрол, шинжлэх ухааны шинэ хэв шинж бүхий тогтолцоо бүрдүүлэх гэж
5. Төрийн өмчийн их, дээд сургуулийн бие даасан байдлыг хангаж, дээд боловсролд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд баримжаалсан мэргэжилтэн бэлтгэх, стандартад суурилсан чанарын хяналтын бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлж, судалгаанд

суурилсан их сургуулийг хөгжүүлнэ (МУ-ын ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр)

6. 2.3.7. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн орон нутаг дахь их сургуулиудыг хотхон хэлбэрт үе шаттайгаар шилжүүлнэ; 2.3.14. Төрийн өмчийн их, дээд сургуулиудын судалгааны болон бусад зардалд төрөөс зарим дэмжлэг үзүүлнэ. (газар, 2020)
7. 2.1.29. Их, дээд сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн хөтөлбөрүүдийн ангиллыг элсэлтийн бодлого, ажиллах хүчний тооцоотой уялдуулж шинэчилнэ. (УИХ, 2020)

Хоёрдугаарт: Улсын зөвлөгөөн, чуулганаас гарсан санаачилга, шийдвэрт: 2018 оны Тогтвортой хөгжил-дээд боловсрол улсын II зөвлөгөөн: Төрийн өмчийн их, дээд сургуулийн үйл ажиллагааны зардлын 30%-аас доошгүйг улсын төсвөөс санхүүжүүлж байх, Монголын багш нарын VII чуулганы тогтоолын 1.8-д Төрийн өмчийн их, дээд сургуулиудын тогтмол зардлыг санхүүжилтийг Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хуульд тусгах хэрэгцээ байгааг онцолсон байна.

БСШУС-ын сайдын 2018 оны А/195 тоот тушаалаар элсэлтийн босго онооны доод хязгаарыг тогтоохдоо орон нутгийн сургуулиудын босгыг 400, төвийн сургуулиудад 450, МУ-ын ЗГ-ын 2014 оны 71-р тогтоол “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам”-ын 4.2.3 багш бэлтгэдэг төрийн өмчийн их, дээд сургуульд амжилттай суралцаж байгаа багшлах дадлагын суралцагчид сургалтын төлбөрийн 30% амьжиргааны зардал олгох зэрэг зохицуулалт шийдвэрүүд хэрэгжиж байна. Эдгээр бодлого, зорилтын хэрэгжилтийн талаар Ховд Их сургууль, Дорнод Их Сургуулийн багш, мэргэжилтэн, удирдлагуудаас авсан үнэлгээг анкетийн аргаар авч үр дүнг боловсруулав.

Судалгааны асуулыг 5-маш сайн, 4-сайн, 3-тийм ч сайн биш, 2-хангалтгүй, 1-огт хэрэгжээгүй, 0-мэдэхгүй гэсэн 6 түвшнээр үнэлүүлэв.



Зураг 4.

Судалгаанд оролцогчид бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт нь хангалтгүй байгаа нь хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр байхгүйтэй холбоотой гэж үзэж байна.

Төв, орон нутгийн их, дээд сургууль, коллежийн мэргэжилтэн бэлтгэж буй чиглэлийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулах, давхардлыг арилгахад голлох үүрэг оролцогчийг тодорхойлох судалгаанаас үзвэл:



Зураг 5.

Боловсролын төрийн захиргааны төв байгууллага, Дээд боловсролын сургалтын байгууллагуудын санаачилга чухал бөгөөд бүс нутгуудад эрэлттэй, хэрэгцээтэй мэргэжлийн судалгаанд тулгуурлаж 91,7% мэргэжилтэн бэлтгэж буй чиглэлийг тодорхойлоход зохицуулалт хийхийг хүсч байна. БСШУС-ын сайдын А/195 тоот тушаалаар элсэлтийн босго оноог нэмэгдүүлсэн шийдвэрийг 62,5% нь дэмжсэн байна.



Зураг 6.

Судалгааны үр дүнгээс харахад бага зэрэг эерэг нөлөө үзүүлсэн ч, алсдаа үр дүн нь гарна гэсэн хүлээлт, хандлага байгааг харж болно. Эндээс үзвэл БСШУСЯ-ны үүрэг, бодлого зохицуулалтын нөлөө чухал байгааг харж болно. Магадгүй мэргэжилтэн бэлтгэж буй давхардлыг арилгах, их дээд сургуулиудын элсэлтийн хязгаарыг журамлах зэрэг зохицуулалт нь орон нутгийн сургуулиудын элсэлтэд эерэг нөлөө үзүүлэх, сургуулиудын чадавх дээшлэх зэрэг өөрчлөлтүүд гарах боломж бий болно.

Дүгнэлт

1. Төр, орон нутгийн их, дээд сургууль, коллежийн элсэлтийн зохистой харьцааг тогтоох асуудалд орон нутгийн оюутны эзлэх хувь сүүлийн 5 жилд тогтмол буурч байна.
2. УИХ, Засгийн газраар батлагдсан төр, засгийн бодлого, зорилтын хэрэгжилт хангалтгүй байгаа бөгөөд түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн олон зохицуулалтуудын нэг нь босго оноог шинэчлэн тогтоосон зохицуулалт үр дүнтэй байна.

3. Төрөөс дээд боловсролыг санхүүжүүлэх боломж хязгаарлагдмал үед бүс нутаг тус бүрийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа хийж бүсчилсэн цаашдын хөгжлийн онцлог хэрэгцээг тодорхойлох, түүнд чиглэсэн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх хэрэгтэй юм.

ENROLLMENT OF LOCAL UNIVERSITIES STATUS, POLICY OBJECTIVES AND IMPLEMENTATION

Abstract

The number of students who study at the local university has been decreasing year by year based on influence of university finance for the last five years. We must identify the real situation of enrollment to the university and needs.

It's main key in implementing of government policy and some obligations related to lack of implementations of goals.

In this situation, number of students and enrollment are important in accordance with marketing law and lower number of students in the local university needs to collaborate and support by the government.

Key words: local university, enrollment, finance, support and obligations

Ном зүй:

1. "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого. УБ.
2. БСШУС-ын сайдын 2018 оны А/195 тоот тушаал
3. "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам" Монгол Улсын ЗГ-ын 2014 оны 71-р тогтоол
4. Дээд боловсролын 2018-2019 оны хичээлийн жилийн статистик. УБ. БСШУСЯ.
5. Дээд боловсролын хөгжлийн бодлогын зорилт-2021; Дээд боловсролын элсэлтийн бодлогын шинэчлэлийн бодлогын стратегийн зорилт; 4.3 .
6. Заяадэлгэр.А. (2011). Боловсролын эдийн засаг . УБ.
7. Монгол улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, баримт бичиг УБ
8. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр. УБ.
9. Монгол улсын Дээд боловсролын тухай хууль, Дээд боловсролын санхүүжилт, нийгмийн баталгааны тухай хуулиуд